**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 27 өдөр Дугаар А/682 Улаанбаатар хот

"Багахангай мах боловсруулах үйлдвэр"
Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрын эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,499,545.00 /гурван сая дөрвөн зуун ерэн есөн мянга таван зуун дөчин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг "Багахангай мах боловсруулах үйлдвэр" ОНӨААТҮГ /Ц.Энхбаатар/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 3 499,545.0 /гурван сая дөрвөн зуун ерэн есөн мянга таван зуун дөчин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг "Багахангай мах боловсруулах үйлдвэр" ОНӨААТҮГ /Ц.Энхбаатар/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ~~
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

01797

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны ..12...дугаар сарын 27 өдрийн Б/682 тоот тушаалын хавсралт

# Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багахангай мах боловсруулах үйлдвэр ОНӨААТҮГ

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ЭБХХХК-ын хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Машин, тоног төхөөрөмж** | | | | | | | | | | |
| 1 | Зөөврийн компьютер | 5 | ш | 1 | 1,300,000.00 | 1,300,000.00 | 1,300,000.00 | - | эвдэрсэн, ашиглах боломжгүй | татах |
| 2 | компьютер Делл | 5 | ш | 2 | 908,909.00 | 1,817,818.00 | 1,817,818.00 | - | эвдэрсэн, ашиглах боломжгүй | татах |
| 3 | принтер HP-Lazerjet | 5 | ш | 1 | 381,727.00 | 381,727.00 | 381,727.00 | - | эвдэрсэн, ашиглах боломжгүй | татах |
| **Машин, тоног төхөөрөмжийн дүн** | | | | **4** | | **3,499,545.00** | **3,499,545.00** | - | | |
| **Нийт дүн** | | | | | | | | - | | |
| Үүнээс: Худалдах хөрөнгө | | | | | | | | | | |
| Актлах хөрөнгө | | | | | | | | | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | **3,499,545.00** | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | | | | | |